



ДУНДГОВЬ АЙМАГ  
ДЭЛГЭРЦОГТ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2020 оны 03 сарын 17 өдөр

Дугаар 4/36

Амардалай

2020 оныг “Бүтээн байгуулалт-Иргэдийн оролцоотой ажиллаж, амьдрах орчныг сайжруулах жил” болгох тухай

Монгол улсын Их Хурлын 2016 оны 19 дүгээр тогтоолоор батлагдсан “Монгол улсын Тогтвортой хөгжлийн үзэл баримтлал-2030”-ын зорилт, Засгийн газрын 2016 оны 121 дүгээр тогтоолоор батлагдсан “Засгийн газрын 2016-2020 оны Үйл ажиллагааны төлөвлөгөө”, Дэлгэрцогт сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2016 оны 12-р сарын 19 ны өдрийн 01 дүгээр тогтоолоор батлагдсан сумын “Засаг даргын үйл ажиллагааны 2016-2020 оны төлөвлөгөө”-г үндэслэн ЗАХИРАМЖЛАХ НЬ:

Нэг: 2020 оныг “Бүтээн байгуулалт-Иргэдийн оролцоотой ажиллаж, амьдрах орчныг сайжруулах жил” болгон зарласугай.

Хоёр: 2020 оныг “Бүтээн байгуулалт-Иргэдийн оролцоотой ажиллаж, амьдрах орчныг сайжруулах жил”-ийн ажлыг зохион байгуулах ажлын хэсгийг доорхи бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Ажлын хэсгийн ахлагч: З.Наранмандах /Засаг даргын орлогч/

Гишүүдэд: С.Нарантунгалаг /ЗДТГ-ын дарга/

Н.Загдхорол /ИТХ-ын нарийн бичгийн дарга/

Ш.Отгонцэцэг /Соёлын төвийн эрхлэгч/

Х.Эрдэнэтуяа /Хүүхдийн цэцэрлэгийн эрхлэгч/


М.Сэрсэндэмид /ЕБС-ийн захирлын үүрэг гүйцэтгэгч/

О.Балжинням /ЭМТ-ийн даргын үүрэг гүйцэтгэгч/

Гурав: Салбар ажлын хэсгүүдийг хавсралтаар баталсугай.

Дөрөв: Тухайн жилийн хүрээнд хийгдэх ажлын төлөвлөгөөг гарган батлуулж, хэрэгжилтийг хангаж, явцын тайланг 2020 оны 06, 11-р сарын 10 ны дотор сумын Засаг даргын зөвлөлд тайлагнаж ажиллахыг Ажлын хэсгийн дарга /З.Наранмандах/-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



П.ЦОЛМОНБААТАР

4880100083